



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 20 оны 11 дугаар
сарын 11 -ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, 33 дугаар зүйл, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, 35 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.2.3 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.1.5 дахь заалт, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6, 7, 8, 9 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабын бүтцийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабын даргаар Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Б.Ууганбаярыг томилсугай.


3. Улсын онцгой комиссын Шуурхай штабыг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын зохион байгуулалтад 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс шилжүүлсүгэй.

4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабын шийдвэрийг төрийн байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдсүгэй.

5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабын үйл ажиллагааны зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд /Г.Мөнхсайхан/-д даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Г.Мөнхсайхан/, ОБЕГ-ын дарга /Г.Ариунбуян/-д тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Шадар сайд




Я.Содбаатар


Я.СОДБААТАР

2010557

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны
137 дугаар тушаалын 1. дүгээр
хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР
ТАХЛЫН ҮЕД ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРҮҮЛ
МЭНДИЙН УЛСЫН АЛБАНЫ ШУУРХАЙ ШТАБЫН БҮТЭЦ



Монгол Улсын Шадар сайдын 2020 оны
~~137~~ дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН АЛБАНЫ ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штаб (цаашид “шуурхай штаб” гэх) дахь салбар хоорондын байгууллагуудын үйл ажиллагааны харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шуурхай штаб нь тохиолдлын удирдлагын тогтолцооны зарчмаар ажиллаж, бодлогын, зохицуулалтын болон хариу арга хэмжээний гэсэн 3 түвшинтэй байна.

1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх бодлогыг Эрүүл мэндийн сайд удирдаж, өдөр тутмын зохицуулах үйл ажиллагааг Шуурхай штабын дарга чиглүүлэн зохион байгуулна.

1.4. Шуурхай штаб нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайд, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаал, Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005), ДЭМБ-ын зөвлөмжийг тус тус мөрдлөг болгож ажиллана.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1. Эрсдэл, Эрсдэлийн үнэлгээ, Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ, Эрсдэлийн явцын үнэлгээ, Эрсдэлийн түвшин, Эрсдэлийн үнэлгээний хамтарсан баг, Мэдээллийн аюулгүй байдал, Хариу арга хэмжээ, Тохиолдлын удирдлагын тогтолцоо, Шуурхай хариу арга хэмжээний хамтарсан баг, Эрсдэлийн харилцаа холбоо зэрэг нэр томъёог Монгол Улсын Шадар сайд, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-д заасны дагуу ойлгоно.

2.2. Голомтын бүс, Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, Хорио цээрийн дэглэм, Хязгаарлалтын дэглэм, Бэлэн байдал зэрэг нэр томъёог Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу ойлгоно.

Гурав. Шуурхай штабын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг

- 3.1. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штаб нь дараах бүтэцтэй байна.
- 3.2. Шуурхай штаб нь дарга, менежер, 5 баг, 13 бүлэг, 3 хэсэгтэй байна. Үүнд:
 - 3.2.1. Нийгмийн эрүүл мэндийн төлөвлөлт, мэдээллийн баг
 - 3.2.1.1. Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийн бүлэг
 - 3.2.1.2. Хяналт үнэлгээний бүлэг
 - 3.2.1.3. Судалгаа шинжилгээний бүлэг
 - 3.2.2. Хариу арга хэмжээний баг
 - 3.2.2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бүлэг
 - 3.2.2.1.1. Эмнэл зүйн хэсэг
 - 3.2.2.1.2. Лабораторийн хэсэг
 - 3.2.2.1.3. Халдварын сэргийлэлт, хяналтын хэсэг
 - 3.2.2.2. Эрсдэлийн харилцаа холбооны бүлэг
 - 3.2.2.3. Татан авалтын бүлэг
 - 3.2.3. Хангалтын баг
 - 3.2.3.1. Эрүүл мэндийн салбарын хангалтын бүлэг
 - 3.2.3.2. Бусад салбарын хангалтын бүлэг
 - 3.2.4. Санхүүгийн баг
 - 3.2.4.1. Эрүүл мэндийн салбарын санхүүгийн бүлэг
 - 3.2.4.2. Бусад салбарын санхүүгийн бүлэг
 - 3.2.5. Захиргааны баг
 - 3.2.5.1. Эрүүл мэндийн салбарын захиргааны бүлэг
 - 3.2.5.2. Бусад салбарын захиргааны бүлэг
 - 3.2.5.3. Гадаад харилцааны бүлэг
- 3.3. Шуурхай штаб дахь эрүүл мэндийн салбарын менежер, баг, бүлэг, хэсгийн ахлагч гишүүдийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар, бусад салбарын баг, бүлэг, хэсгийн ахлагч, салбар хоорондын уялдааг ханган ажиллах үүрэг бүхий гишүүдийг Шадар сайдын тушаалаар томилно.

Дөрөв. Шуурхай штабын албан тушаалтны үүрэг

- 4.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь шуурхай штабыг нэгдсэн удирдлагаар хангах бөгөөд бодлогын түвшинд дараах удирдлагыг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.1.1. Үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллээр Улсын онцгой комисс, холбогдох байгууллага, албан тушаалтныг хангана.
 - 4.1.2. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газар, Улсын онцгой комисст холбогдох шийдвэр гаргуулахаар санал тавина.
 - 4.1.3. Улсын онцгой комиссын даргыг мэргэжил, аргазүйн зөвлөгөөгөөр хангана.
 - 4.1.4. Шуурхай штабыг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.
 - 4.1.5. Штабын дарга, менежерийг чиглүүлж, бодлогын дэмжлэг үзүүлэх, хариу арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой үүрэг, даалгавар өгнө.
 - 4.1.6. Шуурхай штаб дахь эрүүл мэндийн салбарын бие бүрэлдэхүүнийг өөрчлөх шийдвэрийг гаргана.
 - 4.1.7. Хариу арга хэмжээнд шаардлагатай зардлыг төлөвлөх, зарцуулах шийдвэрийг гаргаж, хяналт тавина.

4.1.8. Шуурхай штабын нэгдсэн тайланг баталгаажуулж, холбогдох байгууллагад танилцуулна.

4.1.9. Бусад.

4.2. Шуурхай штабын даргын үүрэг:

4.2.1. Шуурхай штабын даргыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын даргын тушаалаар томилно.

4.2.2. Шуурхай штабын бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн яамны нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний асуудал хариуцсан холбогдох албан тушаалтан, Гамшгаас хамгаалах улсын албад, төрийн цэргийн байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл багтана.

4.2.3. Шуурхай штабын дарга нь Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабыг зохицуулах түвшний удирдлагаар хангаж ажиллана.

4.2.4. Шуурхай штабын даргын өгсөн үүргийг штабын гишүүд биелүүлнэ.

4.2.5. Шуурхай штабын даргын дэргэд хэвлэл мэдээлэл, аюулгүй байдал хариуцсан ажилтан болон холбогчид ажиллана.

4.2.6. Штабын дарга нь дараах үүргийг хүлээнэ:

4.2.6.1. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулалтаар хангана.

4.2.6.2. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүдийг мэдээллээр хангах, өгөгдсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлнэ.

4.2.6.3. Шуурхай штабын менежерийг удирдлагаар хангана.

4.2.6.4. Бусад.

4.2.7. Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан нь дараах үүргийг хүлээнэ.

4.2.7.1. Шуурхай штабын даргын удирдлага дор штабын үйл ажиллагааны тухай мэдээллийг олон нийтэд хүргэнэ.

4.2.7.2. Мэдээллийг Шуурхай штабын менежерээр хянуулж, олон нийтэд хэвлэл мэдээллээр түгээнэ.

4.2.8. Аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан нь дараах үүргийг хүлээнэ.

4.2.8.1. Шуурхай штабын дотоод аюулгүй байдлыг хариуцна.

4.2.8.2. Шуурхай штабын тогтвортой үйл ажиллагаа, ажлын ачааллыг тэнцвэржүүлнэ.

4.2.8.3. Багийн гишүүдэд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, аюулгүй байдлыг хангана.

4.2.8.4. Штабын бүрэлдэхүүний ирц, ажиллах цагийн бүртгэлд хяналт тавина.

4.2.8.5. Шуурхай штабын даргын гаргах шийдвэрийг хууль эрх зүйн чиглэлээр хянаж, хуулийн зөвлөгөө өгнө.

4.2.9. Холбогч нь дараах үүргийг хүлээнэ.

4.2.9.1. Шуурхай штабын даргыг багуудын үйл ажиллагааны талаар мэдээллээр хангаж, өгөгдсөн үүргийг түгээнэ.

4.2.9.2. Багууд хоорондын харилцан ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

4.2.10. Бусад.

4.3. Менежерийн үүрэг:

4.3.1. Шуурхай штабын менежерийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Эрүүл мэндийн сайд томилно.

4.3.2. Шуурхай штабын даргыг мэргэжил аргагүйгээр хангана.

4.3.3. Шуурхай штабын даргын өгсөн үүргийг хэрэгжүүлж, багуудын үйл ажиллагааг зохицуулж, шуурхай штабын багуудад дэмжлэг үзүүлж ажиллах бөгөөд багуудын тавьсан асуудлыг шуурхай штабын даргад мэдээлж, шийдвэрлүүлнэ.

4.3.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт хийх, тэмцэх, хариу арга хэмжээний төлөвлөлтийг зөвлөмжөөр хангана.

4.3.5. Шуурхай штабын багуудын харилцан ажиллагааны талаар шуурхай штабын даргыг мэдээллээр хангана.

4.3.6. Хүний нөөц, санхүүгийн болон техникийн дэмжлэг авах талаар шуурхай штабын даргад мэдэгдэж чиглэл авна.

4.3.7. Орон нутгийн шуурхай штабуудад мэргэжил арга зүйн зөвлөмж өгнө.

4.3.8. Бусад.

4.4. Нийгмийн эрүүл мэндийн төлөвлөлт, мэдээллийн багийн үүрэг:

Нийгмийн эрүүл мэндийн төлөвлөлт, мэдээллийн баг нь Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт, Хяналт үнэлгээ, Судалгаа шинжилгээний бүлгүүдээс бүрдэнэ.

4.4.1. Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийн бүлгийн үүрэг:

4.4.1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлийн үнэлгээ хийнэ.

4.4.1.2. Олон эх сурвалжит тандалтын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ бүрийн үр дүнг мэдээллийн санд оруулна.

4.4.1.3. Хариу арга хэмжээний багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.

4.4.1.4. Багуудаас төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардлагатай саналуудыг авч нэгтгэн, менежерт хүргэнэ.

4.4.1.5. Шуурхай штабын бусад багуудтай хамтран ажиллана.

4.4.1.6. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах заавар, журам, зөвлөмж зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулж, батлуулна.

4.4.1.7. Бусад.

4.4.2. Хяналт үнэлгээний бүлгийн үүрэг:

4.4.2.1. Нөхцөл байдлын өөрчлөлт, холбогдох салбар, байгууллагын хариу арга хэмжээний явцыг хянана.

4.4.2.2. Мэдээллийн эх үүсвэр, нарийвчилсан үзүүлэлт, үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох, хариу арга хэмжээ нь зорилгодоо нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

4.4.2.3. Хариу арга хэмжээний явцад дүн шинжилгээ хийж, шаардлагатай зөвлөмжөөр шуурхай штабын дарга, менежерийг хангах, зөвлөмж гаргах, холбогдох баг, бүлэг, хэсгүүдэд хүргүүлнэ.

4.4.2.4. Мөрдөгдөж байгаа эрхзүйн баримт бичиг, тушаал, заавар нь халдварын үе шатад тохирч байгаа эсэх, хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийнэ.

4.4.2.5. Бусад.

4.4.3. Судалгаа шинжилгээний бүлгийн үүрэг:

4.4.1.8. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой дотоод болон гадаадад хийгдэж байгаа судалгаа, шинжилгээний үр дүнг нэгтгэх, шуурхай штабыг холбогдох мэдээллээр шуурхай хангах

4.4.1.9. Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээний санал боловсруулах, хүргүүлэх

4.4.1.10 Бусад

4.5. Хариу арга хэмжээний багийн үүрэг:

Хариу арга хэмжээний баг нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, Эрсдэлийн харилцаа холбоо, Татан авалтын бүлгээс бүрдэнэ.

4.5.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүлгийн үүрэг:

4.5.1.1. Эрүүл мэндийн байгууллагуудын өдөр тутмын бэлэн байдлыг хангуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгдсэн зохицуулалтаар хангана.

4.5.1.2. Тусгаарлалт ажиглалтад шаардлагатай байрыг зохицуулж, хүний нөөц, эм, эмнэлгийн тусламж, тоног төхөөрөмжөөр хангах тооцоолол хийж, менежерт санал тавина.

4.5.1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүлэг нь Эмнэл зүй, Лаборатори, Халдварын сэргийлэлт, хяналтын хэсгээс бүрдэнэ.

4.5.1.3.1. Эмнэлзүйн хэсгийн үүрэг:

4.5.1.3.1.1. ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар”-ыг тухай бүр шинэчлэн боловсруулж батлуулна.

4.5.1.3.1.2. Оношилгоо, эмчилгээний талаар эмч, эмнэлгийн ажилтнуудыг үе шаттай сургах асуудлыг шийдвэрлэнэ.

4.5.1.3.1.3. Оношилгоо, эмчилгээний түр зааврын дагуу сэжигтэй болон батлагдсан тохиолдолд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулна.

4.5.1.3.1.4. Ажиглалт, тусгаарлалтад байгаа иргэдийн эмнэлзүйн тандалтын мэдээллийг цуглуулж, мэдээллийн урсгалын дагуу хариу арга хэмжээний багийн ахлагчид мэдээлнэ.

4.5.1.3.1.5. Эмчилгээ, үйлчилгээнд шаардагдах эм тариа, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж болон бусад зүйлсийн нөөцийн судалгааг гаргаж, санхүү, нөөцийн багт тавьж шийдвэрлүүлнэ.

4.5.1.3.1.6. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдолд үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний өдөр тутмын мэдээллийг хариу арга хэмжээний багт хүргүүлнэ.

4.5.1.3.1.7. Эмч, мэргэжилтнүүдийг үе шаттайгаар тогтмол сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, зохицуулалт хийнэ.

4.5.1.3.2. Лабораторийн хэсгийн үүрэг:

4.5.1.3.2.1. Улсын хэмжээнд лабораториудын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, бэлэн байдлыг хангах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.5.1.3.2.2. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар”-ыг ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу тухай бүр ХӨСҮТ дэх салбар хоорондын лабораторийн багтай хамтран шинэчлэн боловсруулж, батлуулна.

4.5.1.3.2.3. Лабораторийн эмч, ажилтнуудыг үе шаттайгаар тогтмол сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, зохицуулалт хийнэ.

4.5.1.3.2.4. Лабораториудад шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, оношлуур, урвалж бодис зэрэг шаардлагатай зүйлсийн тооцоо судалгааг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, хангалтын багт тавьж шийдвэрлүүлнэ.

4.5.1.3.2.5. Лабораторийн шинжилгээний хариуны талаарх маргаан таслах, үр дүнг баталгаажуулах асуудлыг зохицуулна.

4.5.1.3.2.6. Бусад.

4.5.1.3.3. Халдварын сэргийлэлт, хяналтын хэсгийн үүрэг:

4.5.1.3.3.1. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр улсын хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.5.1.3.3.2. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээний түр заавар”-ын дагуу сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах, эмчлэх эмнэлэг, тусгаарлан ажиглах байрны бэлэн байдлыг хангуулах асуудлыг зохицуулна.

4.5.1.3.3.3. Эрүүл мэндийн байгууллагад сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх хариу арга хэмжээг удирдан зохион байгуулна.

4.5.1.3.3.4. Эмч, эмнэлгийн ажилтнуудад халдварын сэргийлэлт, хяналтын талаар тогтмол сургалт зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангана.

4.5.1.3.3.5. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр заавар, зөвлөмжийг тухай бүр шинэчлэн боловсруулж холбогдох газруудад хүргүүлнэ.

4.5.1.3.3.6. Эрүүл мэндийн ажилтнууд, ард иргэдэд зориулсан халдвараас сэргийлэх мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр шинэчлэн боловсруулж, эрсдэлийн харилцаа холбооны багт хүргүүлнэ.

4.5.1.3.3.7. Сэжигтэй болон батлагдсан тохиолдол нас барсан үед цогцсыг оршуулахад бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, оршуулах үйл ажиллагааг холбогдох журам, зааврыг баримтлан орон нутгийн засаг захиргаа болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

4.5.1.3.3.8. Хариу арга хэмжээнд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслийн тооцоолол, нөөцийн судалгааг гаргаж, менежерт танилцуулна.

4.5.1.3.3.9. Бусад.

4.5.2. Эрсдэлийн харилцаа холбооны бүлгийн үүрэг:

4.5.2.1. Хүн амд үнэн, зөв мэдээллийг эрсдэлийн харилцаа холбооны зарчимд тулгуурлан олгоно.

4.5.2.2. Нөхцөл байдлыг үнэлж, харилцааны оролцогч талуудыг тодорхойлж, дэгдэлтийн үе шат бүрт тохирсон эрсдэлийн харилцааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.5.2.3. Эрсдэлийн харилцаа холбоог зохицуулах тогтолцоог бүрдүүлнэ.

4.5.2.4. Шуурхай штабын бүрэлдэхүүнийг эрсдэлийн харилцаа холбооны мэдээллээр хангана.

4.5.2.5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр түгж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хяналт үнэлгээ хийнэ.

4.5.2.6. Олон нийтийн санаа бодлыг идэвхтэй судалж, тандсаны үндсэн дээр мэдээ, мэдээллийг түгээнэ.

4.5.2.7. Төлбөргүй лавлах утас, нээлттэй утас, цахим сүлжээн дэх санал, шаардлагыг тандаж, менежерт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.5.2.8. Оролцогч талууд тулгамдаж байгаа асуудлаа зөв шийдвэрлэхэд нь бодит дэмжлэг болохуйц (төлбөргүй лавлах утас, нээлттэй утас гэх мэт) үйлчилгээг бий болгох, шуурхай утасны дугаарыг олон нийтэд зарлаж, тогтмол ажиллуулж, тухайн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийнэ.

4.5.2.9. Үнэн, зөв, зөрөөгүй мэдээллийг нэг эх үүсвэрээс, нэгэн зэрэг хангах зорилгоор мэдээллийг боломжит сувгуудаар зэрэг түгээх, хэвлэлийн бага хурал, цахим хурал зохион байгуулна.

4.5.2.10. Эрсдэлийн харилцааг олон нийтийн оролцоотой хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

4.5.2.11. Шуурхай штаб болон холбогдох байгууллагуудын коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой зохион байгуулсан цаг тухайд нь сурталчилж, олон нийтэд түгээнэ.

4.5.2.12. Эрсдэлийн харилцаа холбооны арга хэмжээнд, олон нийтийн анхаарлыг хандуулж, мэдээлэл, харилцааны хүртээмжийн талаар хяналт үнэлгээ хийнэ.

4.5.2.13. Шийдвэр гаргагч нарт ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол хийнэ.

4.5.2.14. Буруу, ташаа мэдээллийг олон нийтэд тархахаас сэргийлж, зохицуулалт хийнэ.

4.5.2.15. Бусад.

4.5.3. Татан авалтын бүлгийн үүрэг:

4.5.3.1. Гадаад улс орноос эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийн мэдээллийг олон эх сурвалжит мэдээллийн цахим санд нэгтгэн эрэмбэлж, нэрсийн жагсаалт гаргана. Уг ажиллагааг цахим хэлбэрээр хэрэгжүүлж болно.

4.5.3.2. Тусгаарлан ажиглах байрны бэлэн байдал, нөөцийг бүрдүүлнэ.

4.5.3.3. Тусгаарлан ажиглах байрны нөөц, нутаг буцах хүсэлтэй иргэдийн тоо, байршлыг харгалзан тусгай үүргийн нислэгийн хуваарийн төсөл боловсруулж, батлуулна.

4.5.3.4. Тусгай үүргийн нислэгээр ирсэн иргэдийг улсын хилээр хялбаршуулсан журмаар нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд хуваарилах, тээвэрлэх, байрлуулах ажлыг зохион байгуулна.

4.5.3.5. Тусгаарлан ажиглах байрны аюулгүй байдлыг хангуулж ажиллана.

4.5.3.6. Гадаад улс орноос ирж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай иргэдийг эрэмбэлэн тусгаарлаж хариу арга хэмжээний багт шилжүүлнэ.

4.5.3.7. Бусад

4.6. Хангалтын багийн үүрэг:

Хангалтын баг нь эрүүл мэндийн салбарын болон бусад салбарын хангалтын бүлгээс бүрдэнэ.

4.6.1. Эрүүл мэндийн салбарын хангалтын бүлгийн үүрэг:

4.6.1.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, хэрэгцээг тодорхойлон, нөөцийн зураглал гаргана.

4.6.1.2. Улсын хэмжээний хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийн (эм, урвалж, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хүний нөөц, техник хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл гэх мэт) судалгаа гаргах, төлөвлөх, хуваарилах, нийгмийн эрүүл мэндийн төлөвлөлт, мэдээлэл болон хариу арга хэмжээний багийн хүсэлтэд дэмжлэг үзүүлнэ.

4.6.1.3. Шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээний эрүүл мэндийн салбарын нөөцийг дайчлах бэлтгэлийг хангуулж, нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, тодотгох, зарцуулалтад хяналт тавина.

4.6.2. Бусад салбарын хангалтын багийн үүрэг:

4.6.2.1. Барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөц зэрэг бүх төрлийн нөөцийг дайчлах стратеги боловсруулж, хэрэгжилтийг хангуулна.

4.6.2.2. Шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээний бүх төрлийн нөөцийг дайчлах бэлтгэлийг хангуулж, нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, тодотгох, зарцуулалтад хяналт тавина.

4.6.2.3. Хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлж гаргана.

4.6.2.4. Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг ажиллах заавар, журмаар хангах, үе шаттайгаар сургалт зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулна.

4.6.2.5. Ар тал, хангалтын /тээврийн хэрэгсэл, харилцаа холбоо, ус, дулаан хувцас, байр, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шатах тослох материал, хоол хүнсний хангамж, эмнэлгийн тусламж, санхүү/ талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, менежерт санал тавин шийдвэрлүүлнэ.

4.6.2.6. Гамшгаас хамгаалах улсын албадын нөөцийн зураглал, хэрэгцээний судалгаанд үнэлгээ хийнэ.

4.6.2.7. Бусад

4.7. Санхүүгийн багийн үүрэг:

Санхүүгийн баг нь эрүүл мэндийн салбар болон бусад салбарын санхүүгийн бүлгүүдээс бүрдэнэ.

4.7.1. Эрүүл мэндийн салбарын санхүүгийн бүлгийн үүрэг:

4.7.1.1. Хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг удирдан зохицуулна.

4.7.1.2. Багууд болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал, илүү цагийг тооцож шийдвэрлэнэ.

4.7.1.3. Багуудын үйл ажиллагааг хэвийн явуулах байр, техник тоног төхөөрөмжөөр хангаж, дэд бүтцийг бий болгох санхүүгийн асуудлыг шийдвэрлэнэ.

4.7.1.4. Өдөр тутмын санхүүгийн тайланг менежерт танилцуулна.

4.7.1.5. Штабын удирдлагын болон багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.7.1.6. Бусад.

4.7.2. Бусад салбарын санхүүгийн бүлгийн үүрэг:

4.7.2.1. Хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг удирдан зохицуулна.

4.7.2.2. Багууд болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал илүү цагийг тооцож шийдвэрлэнэ.

4.7.2.3. Багуудын үйл ажиллагааг хэвийн явуулах байр, техник тоног төхөөрөмжөөр хангаж, дэд бүтцийг бий болгох санхүүгийн асуудлыг шийдвэрлэнэ.

4.7.2.4. Өдөр тутмын санхүүгийн тайланг менежерт танилцуулна.

4.7.2.5. Штабын удирдлагын болон багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.8. Захиргааны багийн үүрэг:

Захиргааны баг нь эрүүл мэндийн болон бусад салбарын захиргааны бүлгээс бүрдэнэ. Захиргааны баг нь бусад багуудын үйл ажиллагааны зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж, хөдөө орон нутагт ажиллах томилолтыг зохицуулах,

голомтод ажиллах хүний нөөцийг бэлтгэх, хурал зөвлөгөөн зохион байгуулах зэрэг асуудлыг хариуцна.

4.8.1. Эрүүл мэндийн салбарын захиргааны бүлгийн үүрэг:

4.8.1.1. Шуурхай штабын бүрэлдэхүүн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын цагийн тооцоог гаргана.

4.8.1.2. Эрүүл мэндийн салбарт шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, татан оролцуулах болон сэлгэнэ.

4.8.1.3. Хүний нөөцийн бэлэн байдалд хяналт тавина.

4.8.1.4. Шуурхай штабын үйл ажиллагааны баримт бичгийг боловсруулан бичиг хэргийг ажиллуулж, архивлана.

4.8.1.5. Тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина.

4.8.1.6. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, холбогдох багуудад хуваарилах, баримт бичгийг архивлана.

4.8.1.7. Бусад.

4.8.2. Гадаад харилцааны бүлэг :

4.8.2.1. Улсын онцгой комисс, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабын шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Шуурхай штаб, Гадаад харилцааны яам, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрууд болон Улаанбаатар дахь дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагууд хоорондын ажлын уялдаа, мэдээлэл солилцоог бэхжүүлэх, холбогдох бусад зохицуулалт хийх.

4.8.2.2. Гадаад улс орнуудын Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдал, вакцин, хилийн болон хорио цээрийн дэглэмийн талаарх Улсын онцгой комисс, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штаб болон холбогдох бусад байгууллагыг мэдээ мэдээллээр тогтмол хангах.

4.8.2.3. Цар тахлын улмаас тогтоосон дэглэмийн үед гадаад улсын төр засгийн дээд, өндөр албан тушаалтан болон шаардлагатай бусад зочид төлөөлөгчийг Монгол Улсад хүлээн авах, айлчлал зохион байгуулах, мөн гадаад улсад төрийн дээд, өндөр түвшинд айлчлал хийх тохиолдолд холбогдох байгууллагуудтай хамтран бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх.

4.8.2.4. Шуурхай штабын зүгээс гадаадын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагатай хийх уулзалтын бэлтгэлийг хангах, зохион байгуулах.

4.8.2.5. Хилийн чанадад байгаа монгол иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг ГХЯ, хилийн чанадад суугаа Монгол Улсын ДТГ-уудаар дамжуулан зохион байгуулах.

4.8.3. Бусад салбарын захиргааны бүлгийн үүрэг:

4.8.3.1. Гамшгийн талаарх мэдээ, мэдээлэл хүлээн авах, цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, дамжуулна.

4.8.3.2. Штабын бүрэлдэхүүний ажилласан цагийн тооцоог гаргана.

4.8.3.3. Шуурхай штабын багуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.8.3.4. Хүч хэрэгслийг бэлтгэх, бэлэн байдалд хяналт тавина.

4.8.3.5. Шаардлагатай хүн хүч хэрэгслийг тодорхойлох, татах, оролцуулах, сэлгэнэ.

4.8.3.6. Захирамжлалын баримт бичиг болон холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, албан бланк, тамга тэмдгийн үйлчилгээ үзүүлнэ.

4.8.3.7. Тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина.

4.8.3.8. Шуурхай штабын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг баримтжуулах, архивлана.

4.8.3.9. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, холбогдох багуудад хуваарилах, баримт бичгийг архивлана.

4.8.3.10. Бусад.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Багууд хоорондоо үйл ажиллагаагаа уялдуулж, хамтран ажиллана.

5.2. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ooOoo